



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 03 сарын 09 өдөр

Дугаар А/20

Мандалговь

“Мөрдөгч хүүхдүүд” цахим хичээлийг
авах тухай

Хүүхдийн эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, 15.1.5, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.5, 18.1.6, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А/23, 27 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Аргачлал зардлын норматив батлах тухай” журмын 3 дугаар хавсралт, Төсвийн төвлөрүүлэн захирагчаас Төсвийн шууд захирагчтай 2023 онд байгуулсан Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.1.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хүүхдийн аюулгүй байдлын мэдлэг олгох зорилгоор “Мөрдөгч хүүхдүүд” цахим хичээлийг бэлтгэсүгэй.

2. Үйл ажиллагаанд шаардагдах төсвийг хавсралтаар баталсугай.

3. Үйл ажиллагаанд шаардагдах 5,900,000 (Таван сая есөн зуун мянга) төгрөгийг Урьдчилан сэргийлэх үйлчилгээний зардлаас санхүүжүүлэхийг Нягтлан бодогч (С.Чинбат)-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтийг хангаж, үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Залуучуудын хөгжил, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа, оролцоог хариуцсан ажилтан (Г.Мандухай)-д үүрэг болгосугай.

5. Хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2023 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Даргын дэргэдэх зөвлөлд танилцуулахыг Залуучуудын хөгжил, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа, оролцоог хариуцсан ажилтан (Г.Мандухай)-д даалгасугай.

ДАРГА



Ц.ГАНЗОРИГ

482301039

Дундговь аймгийн Гэр бүл, хүүхэд,
залуучуудын хөгжлийн газрын даргын
2023 оны 03 дүгээр сарын 09-ны өдрийн
1/20 тоот тушаалын 1. дүгээр хавсралт



“МӨРДӨГЧ ХҮҮХДҮҮД” ЦАХИМ ХИЧЭЭЛ
АВАХАД ШААРДАГДАХ ТӨСӨВ

№	Зардлын ангилал	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ	Тоо ширхэг	Нийт үнэ
1	Ном	ш	5,900	1,000	5,900,000
Нийт					5,900,000

---oOo---